



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/133

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын шуурхай штабын 2021 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт суманд Коронавируст "Ковид-19"-ын халдварын өвчлөлийн тохиолдол батлагдсантай холбогдуулан удирдлага зохион байгуулалт, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Ганбат (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Шинэбат (Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн захирагч)
Ч.Уранбайгаль (Нэгдсэн эмнэлгийн дотрын их эмч)

2. Холбогдох журмын дагуу удирдлага зохион байгуулалтаар хангаж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан, хэрэгжүүлж буй ажлын явцын мэдээллийг тухай бүр нь танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Л.Ганбат)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

481210429